



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2010 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

┌ Журам батлах тухай ─┐

Монгол Улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг. “Хандив, тусламжийг бүртгэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /С.Мягмардаш/, Төсвийн бодлогын газар /Б.Батжаргал/-т тус тус үүрэг болгосугай

САИД  С.БАЯРЦОГТ

ХУУЛБАР ҮНЭН.

Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын
Санхүү, зохион байгуулалтын хэлтсийн дарга

 Р.ГАНСҮХ

Сангийн яамны Архивын эрхлэгч



Г.ДОЛГОР
2010.03.01



Сангийн сайдын 2010 оны 03 дугаар
сарын 01-ны/ий өдрийн 45 тоот
тушаалын хавсралт

ХАНДИВ, ТУСЛАМЖИЙГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь гадаадын болон дотоодын аж ахуй нэгжээс төрийн байгууллагад өгч буй хандив, тусламжийг Нягтлан бодох бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журмыг хэрэгжүүлэхдээ Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, “Санхүүгийн тайлан, тодруулгын маяг”-ыг мөрдлөгө болгоно.

Хоёр. Хандив тусламжийг бүртгэх журам

2.1. Төрийн захиргааны байгууллага нь хандив, тусламжаар хүлээн авсан хөрөнгийг холбогдох анхан шатны бүртгэлд тусгаж, тайлант хугацаанд санхүүгийн тайланд дараах байдлаар бүртгэж тайлагнана.

а. Мөнгөөр хүлээн авсан үед:

Дт. Мөнгөн хөрөнгө

Кт. Хандив, тусламжийн орлого

б. Мөнгөн бус хөрөнгө хүлээн авсан үед зах зээлийн үнээр эсвэл гэрээнд заасан үнээр бүртгэнэ:

Дт. Бараа материал

Кт. Хандив, тусламжийн орлого

2.2 Олборлох үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуй нэгжээс хандив, тусламжаар хүлээн авсан мөнгөн ба мөнгөн бус хөрөнгийг батлагдсан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын маягтаар тогтоосон хугацаанд гаргаж холбогдох газарт хүргүүлнэ.

2.3 Төрийн захиргааны байгууллага хүлээн авсан хандив, тусламжийн орлогын талаар улирал, жилийн санхүүгийн тайланд тодруулгыг холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу хийнэ.

2.4 Хандив, тусламжаар хүлээн авсан хөрөнгө, түүний зарцуулалтын талаар олон нийтэд зохих журмын дагуу мэдээлнэ.